

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛЫН НОГООН НАМЫН
“НОГООН СОНГОЛТ”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ. МОНГОЛЫН НОГООН НАМ – НИЙГМИЙН БАРИМЖААТАЙ,
ДЭВШИЛТЭТ НАМ

1.1. Эрхэм ёс

1.2. Эх үүсгэл, замнал

1.3. Гэрэлт ирээдүй, цэвэр төрийг цогцлоох

ХОЁР. ЦЭВЭР ТӨРИЙН “ГУРВАН ЦЭВЭР” ХӨГЖЛИЙН НОМЛОЛ

2.1. ЦЭВЭР ТӨРИЙН “ХАР ХАЙРЦАГ”-НЫ БОДЛОГО

2.1.1. Монголын ард түмний “Ирээдүйн сан”

- Үндэсний аюулгүй байдал
- Ард иргэдээ болзошгүй эрсдэлээс хамгаалах
- Нийгмийн зөвшилцлийг хангах

2.2. ЦЭВЭР НИЙГЭМ

2.2.1. Хууль зүй, Шударга ёсны яам

- Оролцооны ардчилал, эрх зүйт төр
- Шударга ёс
- Хүний эрх, эрх чөлөө


2.2.2. Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын яам

- Энэрэнгүй төрт ёс
- Куба улсын амжилтыг нутагшуулах
- Дэвшилтэт даатгал, хүрэлцээтэй тэтгэвэр

2.2.3. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам

- Гарааны ижил нөхцөл
- Уламжлалт соёлоо хадгалан сонгодог урлагийг хөгжүүлнэ
- Дагаж бус угтаж хөгжих

2.2.4. Гадаад бодлогын яам



(Handwritten signatures in blue ink)

- Дэлхийн хамтын нийгэмлэгийг дэмжих
- Эвсэлд үл нэгдэж төвийг сахих
- “Гурван тулгуурт” бодлого

2.2.5. Хилийн цэргийн яам

- Мэргэжлийн армитай байх
- Ургах нарнаас угтах наран зүг
- Аюулаас хамгаалах бодлого

2.3. ЦЭВЭР ЭДИЙН ЗАСАГ

2.3.1. Сангийн яам

- Экологийн баримжаатай эдийн засгийн тогтвортой хөгжил
- Татварын шаталсан тогтолцоо, баячуудын татвар
- Зээл, өрийн бодит харьцааг хянах

2.3.2. Дэд бүтцийн яам

- Нөхөн сэргээгдэх нөөц баялаг дээр суурилсан эрчим хүч
- Зам, тээвэр, харилцаа холбооны цогц сүлжээ
- Дэд бүтцээс ангид барилгажуулалт

2.3.3. Хөдөө аж ахуй, Аж үйлдвэрийн яам

- Эрчимжүүлсэн газар тариалан
- Уламжлалт мал аж ахуй
- Төрийн оролцоот жижиг, дунд үйлдвэр

2.4. ЦЭВЭР БАЙГАЛЬ ОРЧИН

2.4.1. Байгаль хамгаалал, Ногоон хөгжлийн яам

- Дэлхийн экологи Монголоос
- Ногоон эдийн засаг
- Эрдэс баялгийг Эрдэнэтийн зарчмаар

ГУРАВ. “ЦЭВЭР ТӨР”-ИЙН ХҮЛЦЭШГҮЙ 13 “АЛДАС”

ДӨРӨВ. “ЦЭВЭР ТӨР”-ИЙГ СОНГОХ “НОГООН СОНГОЛТ”



НЭГ. МОНГОЛЫН НОГООН НАМ – НИЙГМИЙН БАРИМЖААТАЙ, ДЭВШИЛТЭТ НАМ

Монголын Ногоон нам (МНН) нь Даян Дэлхийн Ногоонтнуудын тунхагийн үзэл санааг тусган Монгол улсад “Экологийн баримжаатай нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах” хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхийг эрхэмлэнэ.

1.1. Эрхэм ёс

Бид эх орондоо ардчилал, шударга ёсыг төлөвшүүлэхийн төлөө ажиллаж, иргэн хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгаатай эдлэх эрхийг эрхэмлэн, аливаа ялгаварлан гадуурхах үзэл, дарангуйлалын эсрэг тууштай тэмцэнэ. МНН нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдлөгө болгон ажиллаж, шударга зарчмын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулан эрх зүйт төрийг цогцлоохын төлөө зүтгэнэ.

1.2. Эх үүсгэл, замнал


Монголын Байгаль Хамгаалах Холбооны гишүүд 1988 онд “Ногоон зам”, 1989 онд “Монголын Ногоонтны Хөдөлгөөн” байгуулан ардчилал, шинэчлэлийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож “Монголын Ардчилсан Холбоо”-г үүсгэн байгуулалцсан билээ.

Дээрхи гишүүд Сүхбаатарын талбай дээр болж байсан ардчилал, шинэчлэлийн төлөөх тэмцлийн үеэр Монголын Ногоон намыг байгуулах тунхагийг 1990 оны 3 дугаар сарын 9-ний өдөр зарлаж, намаа үүсгэн байгуулах хурлаа мөн оны 5 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, тухайн сардаа 5 дугаар сарын 26-ны өдөр Монгол улсын Дээд шүүхэд Монгол улсын гурав дахь намаар бүртгүүлэн, 3000 гишүүн, 12000 дэмжигчидтэйгээр албан ёсоор үйл ажиллагаагаа эхэлсэн.

МНН-ын гишүүдийн идэвхи зүтгэл, намын зүгээс явуулсан лобби ажлын үр дүнд “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2.-т тусгуулсан гэж бид үздэг.

УИХ-ын 1996 оны сонгуульд “Ардчилсан Холбоо” эвсэлд орж ялалт байгуулан тухайн үеийн намын дарга асан Д.Басандорж Байгаль Орчны Яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж төр барилцаж байсан. УИХ-ын 2000 оны сонгуульд шинээр байгуулагдсан ИЗН-тай эвсэн тус намын дарга С.Оюунд УИХ-ын гишүүний суудал авч өгсөн. Үүний улмаас АН-тай харилцаагаа муутгахад хүрсэн боловч ИЗН бидний дэмжлэгийг үл харгалзан эвслийн гэрээг зөрчиж, 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд бие дааж ажилласан нь намын зарим гишүүдэд сургамж болсон.

Бид 2004 оноос иргэний хөдөлгөөнийг дэмжих бодлого барьж Монголын Социал-демократ Хөдөлгөөн, Эрүүл Нийгэм-Иргэний Хөдөлгөөн, Иргэний Холбоо зэрэг ТББ-уудтай хамтран ажилласан билээ. МСДН, ИХН-уудтай хамтран “Иргэний Эвсэл” байгуулж 2008 оны УИХ-ын сонгуульд оролцсон. Тус сонгуулиар тухайн үеийн МНН-ын хоёр даргын нэг Д.Энхбат УИХ-ын гишүүнээр сонгогдож, МНН анх удаа УИХ-д төлөөлөлтэй болсноор хууль тогтоох үйл ажиллагаанд шууд оролцох эрхтэй болсон. Үүний үр дүнд “Ан агнуурын аялал жуулчлал”-ыг хорих, “Мод тарих өдөр”-тэй болох зэрэг олон ажлыг зохион байгуулж, байгаль хамгаалах хууль эрх зүйн орчныг төгөлдөржүүлэхэд манай нам хувь нэмрээ оруулсан болно.




ИЗН 2012 оны УИХ-ын сонгуулиас өмнө бидэнтэй нэгдэж нэг нам болж сонгуульд оролцох санал дэвшүүлсэн боловч бид урьдын гашуун туршлага, бусдын алдаанаас сургамж аван энэ нэгдлийг дэмжихгүй байлаа. Гэвч тухайн үеийн намын удирдлагууд С.Оюун гишүүний хувь хүний онцлогт хууртан ИЗН-д орж 2012 оны 3 дугаар сард ИЗН-ын нэрийг өөрчлөн Иргэний Зориг Ногоон Нам болгон бүртгүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн билээ. Энэ нь яваандаа Монгол улсын байгаль орчныг хамгаалах бодлогыг либералчлан бизнесийн орчинд нийцүүлэн хууль эрх зүйн орчныг өөрчлөхөд хүргэсэн явдалд МНН өнөөг хүртэл эсэргүүцлээ илэрхийлсээр ирсэн.

МНН нь 2012 оны УИХ-ын сонгуульд бусад намуудын эвсэх саналыг хэлэлцэн санамж бичиг хүртэл байгуулан ажиллаж байсан боловч тухайн үеийн “Сонгуулийн тухай хууль”-ийн хүрээнд улс төрийн намууд эвсэх нь эрсдэл дагуулсан асуудал болох тул иргэний нийгмийг дэмжих жанжин шугамаа даган, эзэн Чингис хааны 850 жилийн ойг билигшээж, хаан Богдоороо овоглон олон түмнийг өвөг дээдсийн мэдлэг ухамсрын өвөөр соён гэгээрүүлэх зорилтыг мөрдлөгө болгосон “Чингэс хааны дэлхийн академи”-ийн гишүүдийг дэмжин МНН-ын нэр дор сонгуульд оруулсан билээ.


Бид тухайн үед 100 гаруй хүнийг УИХ болон Нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшүүлж МНН-ын түүхэнд хамгийн олон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулж чадсан боловч ИЗНН-ын “Ногоон” гэдэг тодотгол, мөн сонгуулийн тооллогын “хар машин”-ы үр дүнд 2008 оны УИХ-ын сонгуульд авч байсан дүнгээсээ даруй хоёр дахин бага санал авсан.

МНН 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд тодорхой учир шалтгааны дор, ялангуяа цөмийн хөнөөлийн асуудлаас шалтгаалан ерөнхийлөгч Ц.Элбэгдоржоос зайгаа барьж, харин байгаль экологийн төлөө тууштай зогсдог Б.Бат-Эрдэнэ “аварга”-аа дэмжих сонголтыг улс төрч гэхээсээ илүүтэйгээр байгаль хамгаалагчийн сэтгэлээр хийсэн болно.

Бид Монголын улс төрийн амьдралд намын удирдлага, бүтэц зохион байгуулалтыг ардчилалын зарчим, ил тод байдал, хяналтын үзэл баримтлалд нийцүүлэх үүднээс даян дэлхийн Ногоон намуудын жишгийг дагаж намаа хоёр даргатай болгосон нь өнөөгийн Монголын улс төрийн орчны бодит дүр төрх, ялангуяа тухайн үеийн ИЗНН гурван даргатай болж энэ асуудлыг “дампууруулж” олны ойлголтыг гажуудуулсан зэргээс болж 2012 оны 11 дүгээр сард МНН-ын ээлжит Их хурлаар дүрэмдээ өөрчлөлт оруулж буцаж нэг даргатай болсон бөгөөд намын даргаар өнөөг хүртэл Олзодын Бум-Ялагч сонгогдон ажиллаж байна.

МНН нь “Даян Дэлхийн Ногоонтнууд”-ын сүлжээнээс ИЗНН-ыг 2015 оны 6 дугаар сард албан ёсоор хасуулах асуудлыг олон улсын хэмжээнд шийдүүлсэн бөгөөд манай нам “Ази, Номхон далайн Ногоон Холбоо”-нд улс, эх орноо төлөөлөн ажиллаж байна.

МНН нь 2016 оны УИХ-ын сонгуульд “прагматик улс төрийн бодлого”-ыг дэвшүүлэн, нийгэмд “хувьсгалт өөрчлөлт хийх” чиглэлийг баримтлан эх орондоо тулгараал байгаа олон нийтийг хамарсан ядуурал, нийгмийн баялгийн шударга бус хуваарилалт болон орчны бохирдолт зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд улс төрийн бүхий л арга хэрэгсэл, гишүүдийнхээ бодит боломжийг шавхан ажилласан бөгөөд тухайн үед “Тусгаар тогтнол, эв нэгдэл” эвслийг байгуулан сонгуульд орж ард иргэдийн улс төрийн боловсрол, улс эх орноо хөгжүүлэх үзэл санаанд хувь нэмрээ оруулсан.



Бид Улаанбаатар хотын агаар, хөрс болон усны бохирдол, улс эх оронд нүүрлээд байгаа цөмийн аюул, ялангуяа уран олборлолт зэрэг асуудлыг онцгойлон анхаарч энэ чиглэлээр олон нийтийн байгууллага, иргэдтэй нягт хамтран ажиллаж Монгол улсад гадны гаралтай цөмийн хог хаягдал байршуулах, атомын цахилгаан станц барих асуудлыг зогсоосон.

Бид 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулиар “МАНАН”-гийн эсрэг улстөрийн намуудын байр суурийг илэрхийлсэн нэгдмэл хүчин бүрдүүлэн сонгуульд оролцох аргачлалыг дэмжин, эвсэл байгуулах ажлыг сонгуулийн үр дүнг харгалзан зохион байгуулах саналыг дэвшүүлж сонгуулийн өмнө эвсэл байгуулах хүсэлтэй тодорхой нам, улстөрийн хүчинд албан ёсоор мэдэгдэн энэ сонгуульд аливаа эвслээс ангид дангаар орохоор болсон болно.

1.3. Гэрэлт ирээдүй, цэвэр төрийг цогцлоох

Монгол улсын ирээдүй төр засаг барьж буй улс төрийн нам, улс төрчдөөс шууд хамаарч буй өнөө үед засаглалын төлөө тэмцэгч улс төрийн хүчин нь үзэл санаандаа үнэнч, хүн ардаа гэсэн цайлган сэтгэлтэй, ухаарч сэтгэх чадвартай, уужим талибуун сэтгэлгээтэй гишүүдээр эгнээгээ тэлэх бодлогыг баримтлан тооноос чанарыг эрхэмлэх явдлыг нийгмийн захиалга гэж үзэж байна.

МНН нь бусдын алдаанаас сургамж авч, өөрсдийн эндэгдлийг давтахгүй байх зарчмыг дагаж “нэр хугарахаар яс хугар” хэмээх ёсыг мөрдлөгө болгодог. Байгаль дэлхийгээ хамгаалахын төлөө тэмцдэг Монгол улсын улс төрийн ууган нам, Ази тивийн анхны Ногоон намын хувьд хөгжил дэвшлийн төлөөх тэмцэл, үйл ажиллагаандаа нөр их туршлагыг хуримтлуулан улс эх орны нэр хүндийг олон улсын тавцанд өндөрт өргөн үндэсний хэмжээний намын түвшинд тогтвортой ажиллаж ирсэн болно.

Бид үндэсний хэмжээний намын хувьд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үзэл санааг олон түмэнд түгээн хууль эрх зүйн орчныг чадавхижуулахын төлөө тэмцэж ирсэн бөгөөд нийгэмд шударга ёсыг хэвшүүлэхэд онцгойлон анхаарч “Шударга бол эвтэй, Эвтэй бол хүчтэй” гэсэн эртний сургаалийг сэтгэлдээ тээж улс эх орондоо “Цэвэр төр”-ийг цогцлооно.


ХОЁР. ЦЭВЭР ТӨРИЙН “ГУРВАН ЦЭВЭР” ХӨГЖЛИЙН НОМЛОЛ

МНН нь эх орны үнэ цэнийн илэрхийлэл Монгол хүний мөн чанарыг шүтэн “Эх орон, Эх байгаль, Эв нэгдэл!” уриатай цэвэр төрийн бодлогыг хэрэгжүүлж шударга ардчилсан нийгэм, өвөг дээдсийн үлдээсэн унаган байгаль, тогтвортой хөгжилтэй Монгол орныг хойч үедээ өвлүүлнэ.

Бид эв нэгдэл, эх оронч үзлийг дээдэлсэн, шууд ардчилалын шударга зарчмаар байгуулагдсан, хуулийг сахиулан биелүүлдэг, төрийн залгамж чанарыг хадгалсан, хариуцлага, хяналтын тогтолцоог жигд хангасан, өндөр ёс зүйтэй улс төрийн болон төрийн албан хаагчдаараа дамжуулан чиг үүргээ чандлан биелүүлдэг засаглалын бүтцийг “Цэвэр төр” гэж ойлгоно.

Цэвэр төр нь:

- Үндсэн хуулиа хэлбэрэлтгүй сахин үзэл санааг нь ягштал баримтатгал байна
- Хагаралдаж бутардаггүй, хазайж доройтдоггүй “Хар хайрцаг”-ны бодлоготой байна.





- Шударга сонгуулиар байгуулагдсан, хуулийг сахин биелүүлэгч байна.
- Үндэсний эрх ашгийг сахин хамгаалж иргэд сонгогчдод ил тод, нээлттэй байна.
- Эрх үүргийн тэнцвэр, хариуцлагын тогтолцоог хангана.
- Явцуу ашиг сонирхлоос ангид байж хүн ардаа гэсэн төрийн үйлчилгээг хангадаг байна.
- Эрх мэдэл, эд хөрөнгийн шуналгүй, өндөр ёс суртахуунтай албан хаагчидтай байна.
- Эвсэлд үл нэгдэх төвийг сахисан энх тайванч гадаад бодлоготой байна.
- Байгальд ээлтэй нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг чиг болгосон технологи, мэдээллийн салбарт даяаршлыг зөвшөөрч, төрт ёсны уламжлалаа дээдлэн улс төр, нийгэм, соёл, үндэсний баялгийн хүрээнд дангааршлыг эрхэмлэнэ.
- Шинжлэх ухааны ололт, нарийн мэргэжлийн судалгаа, үндэсний эрдэмтэн мэргэдийн зөвлөмж, бүх нийтийн хэлэлцүүлэг, оролцооны ардчилал зэрэг олон талт хүчин зүйлийг мөрдлөг болгож бодлого, үйл ажиллагаагаа тогтмол цэвэршүүлнэ.

“Цэвэр төр”-ийг цогцлоохдоо өвөг дээдсийн уламжлалд түшиглэн Монгол улсаа Зүүн бүс, Төвийн бүс, Баруун бүс гэсэн гурван бүсэд хувааж засаг захиргааны нэгжийг чадварлаг, цомхон болгоно.

“Цэвэр төр”-ийн Засгийн бүтэц нь цэгцтэй цомхон, чиг үүргийн хувьд давхцалгүй, хүнд сурталгүй, хүн ардаа үзүүлэх үйлчилгээ нь хөнгөн шуурхай байна.

Цэвэр төр нь “Цэвэр нийгэм”, “Цэвэр эдийн засаг”, “Цэвэр байгаль орчин” гэсэн гурван үндсэн бодлогод тулгуурлах бөгөөд эдгээр гурван баганыг бат бөх, тогтвортой байлгахыг эрхэмлэнэ.

- “Цэвэр нийгэм” бодлогыг дараах таван яам хариуцна:
 - Хууль зүй, Шударга ёсны яам
 - Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын яам
 - Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам
 - Гадаад бодлогын яам
 - Хилийн цэргийн яам
- “Цэвэр эдийн засаг” бодлогыг дараах гурван яам хариуцна:
 - Сангийн яам
 - Хөдөө аж ахуй, Аж үйлдвэрийн яам
 - Дэд бүтцийн яам
- “Цэвэр байгаль орчин” бодлогыг дараах яам хариуцна:

- Байгаль хамгаалал, Ногоон хөгжлийн яам

Дээрхи бодлогын яамд нь төрийн бодлогын хэрэгжилтэд салбар бүртээ хяналт тавьж үйл ажиллагаагаа төгөлдөржүүлэн мэргэжлийн өндөр түвшинд төрийн үйлчилгээг үзүүлэх болно.

2.1. ЦЭВЭР ТӨРИЙН “ХАР ХАЙРЦАГ”-НЫ БОДЛОГО

Цэвэр төрийн “Хар хайрцаг”-ны бодлого нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд үнэнч байж үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, тусгаар тогтнолыг хамгаалж, байгаль дэлхийгээ дээдлэн ард түмнийхээ эвсэг дотно, эрүүл тунгалаг, элбэг хангалуун эрхэм сайхан амьдрах нөхцлийг тогтвортой хангаж, эвсэлд үл нэгдэн төвийг сахиж даян дэлхийн улс гүрнүүдтэй энхтайвнаар зэрэгцэн хөгжих ирээдүйг цогцлооход оршино.

Монгол улс “Цэвэр төр”-ийн “Хар хайрцаг”-ны бодлогоо нийгмийн дундын өмч болох “Ирээдүйн сан”-гийн үйл ажиллагаагаар баталгаажуулан хэрэгжүүлнэ.

2.1.1. Монголын ард түмний “Ирээдүйн сан”

Монгол Улсын Үндсэн хуулийн 6.1.-д: “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж заасан нь иргэн бид эх орныхоо байгалийн баялгийг Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу захиран зарцуулах, шийдвэр гаргах халдашгүй дархан эрхтэй гэдгийг тунхагласан байна.

Монгол улсад нийт олборлож буй нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн 10 хувийг “Ирээдүйн сан”-д төвлөрүүлэх үзэл баримтлалыг амьдралд хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх болон шаардлагатай тооцоо судалгааг төрийн болон бусад судалгааны байгууллагатай хамтран гүйцэтгүүлж олон нийтээр хэлэлцүүлэх нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцнэ гэж үзэхийн зэрэгцээ энэ нь Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнол, ард иргэд, ирээдүй хойч үеийн маань оршин тогтнох баталгаа болно.

Тус сан нь цаашид улам арвижих зарчим дээр тулгуурлан ажиллах бөгөөд сангийн хөрөнгийг байршуулсан үйл ажиллагаанаас олсон ногдол ашгийг улс эх орныхоо нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үйлсэд зарцуулах ба “Ирээдүйн сан”-гийн үндсэн хөрөнгө нь халдашгүй дархан байна.

"Ирээдүйн сан" нь улс төрөөс ангид байх зарчимд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах бөгөөд аливаа шийдвэрийг судалгаа шинжилгээнд суурилан гаргана. Нэн шаардлагатай бол шууд ардчилалын зарчимд тулгуурлан бүх ард түмний санал асуулга явуулж болно.

Монгол улсын 16 нас хүрсэн иргэнийг “Ирээдүйн сан”-гийн гишүүнд тооцно. “Ирээдүйн сан”-гийн шийдвэр гаргах дээд байгууллага нь тус сангийн Их хурал байх болно.

“Ирээдүйн сан”-гийн Их хурлын гишүүнээр сум, хороодоос тус бүр нэг хүнийг тухайн орон нутгийн иргэд шууд сонгох ба Их хурал нь өнөөгийн хууль эрх зүйн орчинд нийцэн нийт 482 (330 сум ба 152 хороо) гишүүнтэй байна.



Сангийн Их хурлын гишүүдийг дөрвөн жилийн хугацаатайгаар сонгох бөгөөд уг сонгуулийг УИХ-ын сонгуультай давхцуулан нэг цаг хугацаанд зохион байгуулж санхүү, хөрөнгө мөнгөний асуудлыг "Ирээдүйн сан" хариуцдаг байхаар зохицуулна.

"Ирээдүйн сан"-гийн Их хурал жилд нэг удаа хуралдах бөгөөд шаардлагатай бол ээлжит бус их хурлыг зарлан хуралдуулна.

Их хурлуудын хооронд сангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлыг тухайн Их хурлаас сонгосон "Ирээдүйн сан"-гийн Бага хурал хариуцна. Бага хурал нь нийт 69 ("Ирээдүйн сан"-гийн Их хурлын гишүүдээс 48 хүн, мөн тухайн үеийн Засгийн газраас 21 хүн) гишүүнтэй байх ба улиралд нэг удаа хуралдана. Бага хурал нь "Ирээдүйн сан"-гийн ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулах эрхтэй байна.

Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Бага хурлаас сонгосон "Ирээдүйн сан"-гийн Удирдах зөвлөл хариуцан зохион байгуулж Бага хурлын шийдвэрийг амьдралд хэрэгжүүлнэ. Удирдах зөвлөл нь "Ирээдүйн сан"-гийн ээлжит бус Бага хурлыг зарлан хуралдуулах эрхтэй байна.

"Ирээдүйн сан"-гийн Удирдах зөвлөл нь дараах гурван үндсэн асуудалд анхаарлаа төвлөрүүлэн ажиллах болно. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдал

Монгол улсын "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" болон "Үндэсний аюулгүй байдлын тухай" хуулийн хүрээнд төр засагтай нягт хамтран ажиллах бөгөөд зайлшгүй шаардлагатай төслүүдийн санхүүжилтыг хамтран шийдвэрлэнэ.

- Ард иргэдээ болзошгүй эрсдлээс хамгаалах

Монгол улсын "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн үзэл баримтлалыг амьдралд хэрэгжүүлж ард иргэдээ болзошгүй эрсдлээс хамгаалах үйл ажиллагааг баталгаажуулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монгол улсын иргэний баталгаатай эдлэх эрхийг эдлүүлэхийн төлөө ажиллана.

- Нийгмийн зөвшилцлийг хангах

Монгол улсын "Ард нийтийн санал асуулгын тухай" хуулийг хэрэгжүүлж нийгэмд тулгамдсан тодорхой асуудлаар бүх ард нийтийн дунд хэлэлцүүлэг, санал асуулгыг явуулж нийгмийн зөвшилцлийг ханган ажиллах болно.

2.2. ЦЭВЭР НИЙГЭМ

"Цэвэр нийгэм" нь хүний эрхийг дээдлэн хуулийг сахин биелүүлдэг, шударга ёсыг тогтоохын төлөө тууштай тэмцдэг, эрүүл мэнд, боловсрол, соёл шинжлэх ухааны салбарыг төр нь зонхилон хариуцдаг, "хил, хэл, мал"-аа дээдлэх уламжлалт ухааралдаа тулгуурлана. Гадаад харилцаандаа эвсэлд үл нэгдэн төвийг сахих үзэл санааг хэрэгжүүлэн, хил хязгаарыг сахин хамгаалах үйл хэрэгт бүх нийтийн оролцоог хангаж, мэргэжлийн цомхон, чадварлаг үлгэр жишээ армитай байж шударга, энэрэнгүй, иргэний ардчилсан нийгмийг төлөвшүүлнэ.



(Handwritten signatures in blue ink)

“Цэвэр нийгэм”-ийн хуулийг чандлан сахиулагч, шударга ёсыг эрхэмлэн хангагч үүргийг “Хууль зүй, Шударга ёсны яам” бодлогоор хангаж хариуцан амьдралд хэрэгжүүлнэ.

2.2.1. Хууль зүй, Шударга ёсны яам



Тус яам нь “Оролцооны ардчилал, эрх зүйт төр”, “Шударга ёс”, “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн гурван үндсэн бодлогыг зангидан нийгэмд суурьшуулан хэвшүүлнэ. Үүнд:

Оролцооны ардчилал, эрх зүйт төр

- Монгол улсын төр цэвэр, ард түмэн эв нэгдэлтэй байх нийгмийн үндэс нь улс төрийн намууд хатуу гишүүнчлэлгүй байх явдал гэж үзэн холбогдох хуулиудад өөрчлөлт оруулна.
- Ардчилсан, ил тод, хариуцлагатай засаглалын төлөө тэмцдэг жирийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг тууштай дэмжиж санхүүгийн хөшүүргийн аргачлалыг баталгаажуулна.
- Улс төрийн намуудын сонгуулийн сурталчилгааг төр хариуцаж, тойрогт нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны зардлыг зөвхөн нэр дэвшигч тухайн үеийн иргэдийн дундаж орлогод түшиглэн гаргасан сонгуулийн зардлын дээд хязгаарыг хэтрүүлэхгүй өөрөө бүрдүүлэх зарчмыг хуульчлан мөрдлөг болгож шударга сонгуулийн тогтолцоог хангана.
- Орон нутгийн Иргэдийн хурлын сонгуульд улс төрийн намаас нэр дэвшихийг хязгаарлах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Төр, засгийн байгууллагуудыг чадварлаг, мэргэшсэн, цомхон бүтэцтэй болгож ил тод байдлыг баталгаажуулна.
- Хүчний байгууллагуудын үйл ажиллагааг албан тушаалтан болон бусад хөндлөнгийн нөлөөллөөс ангид байлгах хууль эрх зүйн орчныг чандлан сахиж мөрдлөг болгоно.

Шударга ёс

- Нийгмийн баялгийг иргэддээ тэгш хүртээх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Иргэддээ бүх талаар дэвжин хөгжих “гарааны ижил нөхцөл”-ийг баталгаажуулна.
- Баян ядуугийн ялгааг арилгах тогтолцоо хангана.
- Улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралын бүх хүрээнд хүйсийн тэнцвэр, эрх тэгш байдлыг бүрэн хангана.
- Улс төр, нийгэм, эдийн засгийн өргөн хүрээтэй арга хэмжээнд залуучуудын оролцоог бүх талаар дэмжиж, тэдэнд дуу хоолойгоо өргөх өргөн боломж олгоно.
- Хувь хүнтэй холбоотой шийдвэр гаргах үед түүнийг холбогдох мэдээллээр хангаж, оролцооны шударга тогтолцоог хөгжүүлнэ.
- Шийдвэрийг тухайн асуудалд хамрагдсан иргэдээр нь гаргуулах боломжийг бүрдүүлнэ.
- Тухайн газар нутгийн уугуул иргэд нутагшсан газартаа сэтгэл хангалуун амьдрах бүхий л боломжийг бүрдүүлнэ.



Хүний эрх, эрх чөлөө

- Хүний эрхийн түгээмэл тунхаг, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын гэрээ, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын гэрээ, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенци зэрэг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах олон улсын аргачлалыг дэмжинэ.
- Хүний эрхийг хөсөрдүүлэгч аливаа дарангуйлагч дэглэмүүдийг эсэргүүцнэ.
- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үзлээс ангид байлгах хууль эрх зүйн орчныг мөрдлөгө болгож, тэдний бие даан шийдвэр гаргах эрхийг эрх, цэвэр аюулгүй орчинд амьдарч ажиллах ариун цэврийн эрх, ажлын байрны бэлгийн дарамтанд өртдөггүй байх эрх, олон нийтийн газар чөлөөтэй аюулгүй зорчих эрх зэрэг үндсэн эрхийг нь хамгаална.
- Эмэгтэйчүүдийн боловсрол, эрүүл мэндийн тэгш бус байдлыг арилгана.
- Хувь хүний халдашгүй дархан байдалд халдан ямар ч хэлбэрээр хүч хэрэглэхийг эсэргүүцнэ.
- Садар самууныг сурталчлах явдлыг таслан зогсооно.
- Дэлхий даяар цаазын ялаас татгалзахыг шаардана.
- Ажлын байр аюулгүй байх, ажилчид ачаалалдаа тохирсон цалинтай байх зарчмыг мөрдлөгө болгон нэг цагт ногдох хөдөлмөрийн дундаж хөлсийг зохистой хэмжээг тогтоох судалгааг олон улсын жишгийн дагуу хийнэ.
- Өсвөр насны хүүхэд залуучуудыг хөдөлмөрийн мөлжлөгөөс найдвартай хамгаалж, тэдний чөлөөтэй өсөн бойжих эрхийг эдлүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрх, мөн улс төр, нийгэм, эдийн засгийн аль ч салбарт бусдын нэгэн адил ажиллах эрхийг баталгаажуулна.
- Өмгөөлөл авах эрхээр хангадаг хууль эрх зүйн шударга тогтолцоог бий болгоно.
- Хүний эрхийг тууштай хамгаалж, ард иргэдийнхээ нэр хүнд, хувь хүний биеийн эрүүл мэнд, оюун санааны сайн сайхан байдлыг дэмждэг орчныг бүрдүүлнэ.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөрөнгө мөнгөнөөс ангид байлгах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- “Хүүхэд бол хүн!” гэсэн “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-д тусгасан эрхийг хамгаалах, бодитоор эдлүүлэх аргачлалыг боловсронгуй болгож “Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага”-ын чадамжийг төгөлдөржүүлнэ.
- Монгол улсын Үндсэн хуульд заасан хүйсээр ялгаварлахгүй зарчмыг хангуулж ЛГБТК иргэдийг “хүн” гэж үзэх соёлыг нийгэмд түгээж эдгээр нийгмийн цөөнхийн эрхийг хамгаална.

“Цэвэр нийгэм”-ийн Монгол улсын иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, нийгмийн халамжийн асуудлыг “Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалалын яам” бодлогоор хангаж хариуцан амьдралд хэрэгжүүлэх болно.


2.2.2. Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын яам

Энэрэнгүй төрт ёс




- Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ялангуяа цар тахлын аюул нүүрнээд буй өнөөгийн эрин үед эмнэлгийн анхан шатны тусламж, бүх төрлийн шинжилгээ, эмчийн үзлэг, эмчилгээ, тоног төхөөрөмжийн хангамжинд хяналт тавьж ажиллана.

- Иргэдийн эрүүлийг хамгаалах, тэднийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд нийтийн биеийн тамирыг амьдралд хэвшүүлж бүх нийтээр эрүүл, аюулгүй орчинд аж төрөх нөхцлийг бүрдүүлнэ.
- Архи, тамхи зэрэг хорт зуршил, хар тамхи, мансууруулах бодисын аюулаас ард иргэд, хойч ирээдүйгээ хамгаалахад чиглэгдсэн архидалт, мансуурлын эсрэг хөтөлбөр, санаачилгыг дэмжинэ.
- Иргэдийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн суурь боловсролыг эрс дээшлүүлэх замаар хүн амын өсөлтийг дэмжинэ.
- Эхийн эрүүл мэндийг жирэмслэлтийн эхэн үеэс хамгаалах, ургийн бойжилтыг оношлох, хянах, хүүхдийг нэг нас хүртэлх хугацаанд шаардлагатай нэмэлт хоол, тэжээлээр хангах бодлогыг чадавхижуулна.
- Сум, өрхийн эмнэлэгт анхан шатны тусламж үзүүлэх, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалт хийх, шүдний өвчин эмчлэх, бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирус, сүрьеэгээс сэргийлэх, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлнэ.
- Аймаг, дүүргийн эмнэлгийг хорт хавдрыг эрт оношлох, эмчлэх боломжоор хангаж, эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлж, клиникийн тусгай эмнэлэг, мэргэжлийн төвүүдийн үйлчилгээг хөгжингүй орнуудын түвшинд хүргэнэ.
- Алсын зайны оношилгоо, эмчилгээний аргуудыг эмнэлэгт нэвтрүүлж, хувь хүний өвчний түүхийг цахим картын нэгдсэн сүлжээнд оруулах үндэслэлийг боловсруулна.
- Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчнээр хангана.
- Эмч мэргэжилтнүүдийн цалин, нэмэгдэл, урамшуулал, шагналын тогтолцоог эрүүл мэндийн дэвшилтэт даатгалтай холбон боловсронгуй болгоно.
- Монголын уламжлалт анагаах ухааныг дэлхийд өрсөлдөхүйц жишиг болгон хөгжүүлнэ.
- Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, цар тахал, гэнэтийн аюул ослын эрсдлийг оновчтой шийдвэрлэх менежментийн чадавхийг бэхжүүлнэ.
- Хүн амын ундны усны хангамж, химийн үйлдвэр, ахуйн хог хаягдлын менежментийг багтаасан амьдралын эрүүл орчныг бий болгоно.
- Хүн амыг эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, биологийн идэвхт бодисоор хангахад аюулгүй байдлыг эрхэмлэнэ.
- Эмнэлгийн болон лабораторийн тоног төхөөрөмжийн бодлогыг шинэчилж, нийлүүлэлт, засвар үйлчилгээг сайжруулж, оношилгооны чадавхийг дээшлүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын "Үдийн цай" хөтөлбөрийг чадавхижуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сувилал, сэргээн засах төвүүдийг дүүрэг бүрт байгуулах, эцэг эхэд нь эмчилгээ үйлчилгээний сургалт өгөх кабинет байгуулах ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж тэгш хүртээмжтэй байлгах, дэлхийн стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэд тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлж, эрт үед зөв онош тогтоосноор зөв эмчилгээ, үйлчилгээ авах нөхцөлийг сайжруулна.
- "Хүүхэд бүрт өдөрт 1 аяга сүү" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж хүүхдийн эрүүл мэнд, бие физиологид шаардлагатай амин дэм, эрдэс бодисын дутагдал, бие мах



[Handwritten signature]

бодийн болон оюуны хоцрогдолоос урьдчилан сэргийлж ирээдүйн эрүүл иргэнийг бэлдэнэ.

- Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлж буй хөнгөлөлт тусламж үйлчилгээг оновчтой зөв зохион байгуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхэд зориулсан “тохируулгатай” ажлын байр бий болгох, хөдөлмөрийн хуулийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах “квот”-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эхчүүдийг оруулна.

Куба улсын амжилтыг нутагшуулах

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас БНКУ-ын эрүүл мэндийн тогтолцоог “Дэлхийн өв”-д бүртгэн авсныг тохион даян дэлхийд нутагшуулах тухай уриалга гаргасан тул тус тогтолцоог Монгол улсдаа шууд авч хэрэгжүүлэх бодлогыг дэмжинэ. Уг ажлыг хийж гүйцэтгэхийн тулд дараах шат дараалсан арга хэмжээг авна. Үүнд:

- Куба улсын эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчныг Монгол улсын онцлогт нийцүүлнэ.
- Куба улсын эмнэлгийн мэргэжилтнүүдийг эх орондоо урьж, эрүүл мэндийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг чадавхижуулна.
- Халдварт өвчнийг ул мөргүй арилгахад чиглэгдсэн хөтөлбөрүүдийг Куба улстай хамтран зохион байгуулна.
- Монгол улсын эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг Куба улсын жишиг дээр тулгуурлан зохион байгуулна.
- Биотехнологийн салбарт онцгойлон анхаарч Куба улсын дэвшилтэт арга туршлагыг эх орондоо нутагшуулна.
- ДОХ болон бусад вирусын гаралтай өвчний эсрэг дархлаажуулалтын судалгаа, шинжилгээний ажилд Куба улстай хамтран оролцож мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэнэ.
- Хүүхэд залуучуудын эрүүл мэндийн хамгааллыг баталгаажуулна.

Дэвшилтэт даатгал, хүрэлцээтэй тэтгэвэр

- Амаржсан эхчүүдийн хүүхэд асарсны тэтгэмжийг тухайн үед мөрдөгдөж байгаа цалингийн дундаж төвшинд байлгах үндэслэлийг боловсруулна.
- Дөрөв болон түүнээс олон хүүхэдтэй эхчүүдэд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын урамшууллын тогтолцоог төгөлдөржүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- Гэр бүлд чиглэсэн халамжийн тогтолцоог төлөвшүүлж олон улсын жишигт хүргэх судалгаа шинжилгээнд суурилсан бодлого боловсруулна.
- Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалж, бүтээмж, ур чадварыг хөгжүүлнэ.
- Бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой болгоно.
- Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого баримтлана.
- Монгол улсын иргэн гавъяаныхаа амралтыг эдлэхэд тэтгэвэр нь амар амгалан амьдрахад нь хүрэлцээтэй байх баталгааг бүрэн хангах нийгмийн даатгалын хүмүүнлэг тогтолцоог бүрдүүлнэ.



Handwritten signatures in black ink, appearing to be official signatures, located below the stamp and the list of points.


- Нийгмийн сайн сайхны төлөөх үйл ажиллагаа, сайн дурын тусламж, тэтгэлгийг төрийн бодлогоор дэмжинэ.
- Хүн амын ядуу бүлэгт онцгой хандсан бодлого хэрэгжүүлнэ.
- Нийгмийн хамгааллын санхүүжилт, тэтгэвэр, тэтгэмжийг дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэй оновчтой уялдуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, нийгмийн эмзэг бүлэгт зориулсан халамж, үйлчилгээний бодлогыг тогтвортой хэрэгжүүлнэ.

“Цэвэр нийгэм”-ийн хойч үеэ сурч боловсрох гарааны ижил нөхцлөөр хангаж чанартай боловсрол олгох, уламжлалт соёлоо хадгалан сонгодог урлагийг хөгжүүлэх, “инноваци”-ийг Монгол улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх салбар болгох зэрэг асуудлыг “Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам” бодлогоор хангаж амьдралд хэрэгжүүлнэ.

2.2.3. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам

Гарааны ижил нөхцөл

- Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2. заалтыг үндэслэн өсвөр үеийг боловсрол эзэмших “гарааны ижил нөхцөл”-өөр хангана.
- “Тогтвортой хөгжлийн боловсролын үндэсний хөтөлбөр”-ийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан байнга боловсронгуй болгоно.
- Боловсролын бодлогыг тодорхойлохдоо насан туршдаа суралцахуйн үзэл санаа, суралцахуйн дөрвөн багана, хамтдаа сайн сайхан амьдрах “Дэлхийн иргэний боловсрол”, “Тогтвортой хөгжлийн боловсрол” зэрэг дэлхийн боловсролын талаарх үзэл санаа, чиг хандлагатай нийцүүлэх, сургалтын агуулга, хөтөлбөрт улс төрчдийн зүгээс хөндлөнгөөс оролцохыг хориглох зохицуулалт хийнэ.
- Монгол улсын боловсролын зорилгыг “Тогтвортой хөгжлийн 4-р зорилго”-д нийцүүлэн эрх тэгш, чанартай боловсролд хүн бүрийг тэгш хамруулах, аливаа ялгаатай байдлыг үнэлж, хүндэтгэх үнэт зүйлийг суулгах зэрэг үзэл санааг тусган, иргэдээ бүх шатны боловсролын тогтолцоонд тэгш хамруулан сургах зарчмыг баримталах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Төрийн өмчийн их, дээд сургуулийг хотхоноор зохион байгуулна.
- Гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг аймаг, дүүрэг бүрт нэгээс доошгүй байхаар нэмж байгуулан сургалтын орчин үеийн техник, тоног төхөөрөмж, материаллаг бааз, багшлах боловсон хүчнээр бүрэн хангах замаар эрэлт ихтэй мэргэжилтэй ажилчдыг богино хугацаанд бэлтгэнэ.
- Багшийн мэргэжил, арга зүй, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хууль эрх зүйн орчныг багш нарын хүсэл эрмэлзэл, санал санаачлагыг үндэслэн боловсруулах бодлогыг баримтлана.
- Бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамрагдах боломж нөхцлийг бүрдүүлж хөдөөгийн малчин өрхийн бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг нүүдлийн аж байдал нь тохируулан зохион байгуулна.



(Handwritten signatures in blue ink)

- Үндэсний тэргүүлэх мэргэжилтнийг төрийн бодлогоор дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлж уул уурхай, биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологийн хөгжлийн өндөр түвшинд хүрсэн орнуудад сургах чиглэл баримтлана.
- Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургуулийн бүтэц, хэв шинж, хэмжээ, байршлыг оновчтой болгосон зураглалыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.
- Өндөр чанартай, бүх нийтийг хамарсан анхан шатны боловсролын тогтолцоог баримтлах үүрэг хүлээнэ.
- Монгол үндэстний өв уламжлал, байгаль орчинтойгоо зохицон амьдрах чадварыг олон улсын туршлагатай хослуулан шинжлэх ухаан технологийн ололтод тулгуурласан тогтвортой хөгжил, байгаль орчин, экологийн боловсролыг бүх нийтэд үе шаттайгаар эзэмшүүлнэ.
- Тогтвортой хөгжлийн боловсролын агуулгыг бүх шатны албан болон албан бус сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлж олон нийтэд таниулах мэдээлэл, сурталчилгааны нэгдсэн сүлжээ бий болгох бодлогыг дэмжиж холбогдох судалгаа шинжилгээг боловсруулна.
- Ахлах ангийн сурагчдад дэлхийн нэр хүндтэй их, дээд сургуулиудын тэтгэлэгт тэнцэх, хамрагдах боломжоор хангана. Сурагч бүрийг нийгэмд тустай сайн дурын ажил хийдэг соёлыг нэвтрүүлж энэ тухай харьяа боловсролын байгууллагаас албан ёсны тодорхойлолт гаргаж өгдөг зохицуулалт хийнэ.
- Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг боловсролын салбарт хэвшүүлэх, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн тухай сургалтуудыг эцэг, эх болон асран хамгаалагч, багш нарт тогтмол сургалт хийх тогтолцоог бий болгоно.
- Бага насны хүүхэд болон сургуулийн өмнөх боловсролын түвшинд эцэг, эх байх боловсролыг олгох ба хүүхдийн өсөлт, хөгжил, боловсролд эн тэнцүү анхаарсан хөтөлбөрийг боловсролын хөтөлбөрт оруулна.
- Төсөв, худалдан авалтын үйл ажиллагаанд олон талын хяналт, оролцоог хангах, санхүүжилт, зарцуулалтад сургуулийн зөвлөл, эцэг эхийн зөвлөл, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад хамааралтай талуудын хөндлөнгийн хяналт тавих механизмыг бүрдүүлнэ.
- Залуу судлаачдыг дэмжих зорилтот хөтөлбөр боловсруулах ажлыг дэмжиж шаардагдах судалгаа шинжилгээг эхлүүлнэ, шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийн болон санхүүжилтийн бодлого боловсруулж, хэрэгжилтэд шинэчлэл хийнэ.
- Шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэхэд улсын төсвөөс зарцуулах зардлыг ДНБ-ний 1%-д хүргэнэ.

Уламжлалт соёлоо хадгалан сонгодог урлагийг хөгжүүлнэ

- Монголчуудын уламжлалт соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, сэргээх, үндэсний хийгээд дэлхий дахины танин мэдэхүйн нийтлэг хүртээл болгон дэлгэрүүлэх үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжинэ.
- Сонгодог урлагийн бүх төрлийг жигд хөгжүүлэх, авьяас билигтнүүдээ гадаадын орнуудад сургах нөхцлийг бүрдүүлнэ.
- Үндэсний уламжлалт болон сонгодог урлаг, хүүхдэд зориулсан урлагийн төрлийг төрөөс дэмжих бодлого боловсруулна.



(Handwritten signatures)

- Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана.
- Соёл, урлагийн байгууллагуудын материаллаг бааз, барилга байгууламжийн зориулалт, эрүүл ахуй, гоо зүй, техникийн болон үйлчилгээний чанарт тавигдах орчин үеийн хэрэгцээ шаардлагыг тусгасан стандартыг боловсруулж мөрдөнө.

Дагаж бус угтаж хөгжих

- Санхүү, эдийн засгийн аргаар үндэсний инновацийн тогтолцоог дэмжиж эрх зүй, зохион байгуулалтынх нь үндсийг бүрдүүлнэ. Бусдыг дуурайх бус угтаж хөгжих бодлого хэрэгжүүлнэ.
- Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, суурь технологийг тодорхойлон хэрэгжүүлж, судалгааы боловсруулалтын ажлын сонголтыг сайжруулан үр өгөөжийг дээшлүүлнэ.
- Шинжлэх ухаан, технологийн салбарын удирдлага, үйл ажиллагааны санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний ажилд түлхүү анхаарна.
- Үндэсний хэмжээний томоохон инновацийн төслийг Монгол Улсыг хөгжүүлэх сан, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Шинжлэх ухаан, технологийн сангийн хамтарсан санхүүжилтээр бүрэн мөчлөгөөр нь тасралтгүй хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвшүүлнэ.
- Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн бүхий л хүрээнд инновацийн соёлыг нэвтрүүлнэ.
- Төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, үйл ажиллагааг дэмжин урамшуулах, суурь судалгааны шилдэг бүтээлүүдийг нийтийн хүртээл болгоход төрөөс дэмжлэг үзүүлнэ.

“Цэвэр нийгэм”-ийн Дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эвсэлд үл нэгдэн төвийг сахих, хөрш орнуудын “гурван тулгуурт бодлого” зэрэг найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг “Гадаад бодлогын яам” хариуцан амьдралд хэрэгжүүлнэ.

2.2.4. Гадаад бодлогын яам

Дэлхийн хамтын нийгэмлэгийг дэмжих

- Зөрчлийг зохицуулах, энхийг сахиулах даян дэлхийн байгууллагынх нь хувьд Нэгдсэн Үндэстний Байгууллагыг дэмжиж энхийг сахиулах үйл ажиллагаанд идэвхитэй оролцоно.
- Үй олноор хөнөөх болон ердийн зэвсгийг иж бүрнээр нь эцэслэн хориглох явдлыг баталгаажуулсан олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг тусгасан бүх нийтээр бүрэн зэвсэг хураах ажлыг дэмжинэ.
- Олон улсын гэмт хэргийн шүүхийг дэмжинэ.
- Хэрэгжиж буй энх тайвны хөтөлбөрүүдийг чадавхижуулахад туслана.
- Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд дэлхийн улс орнуудтай найрсагаар харилцаж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг



(Handwritten signatures and official stamps)

улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ.

- Гадаадад байгаа Монгол улсын иргэд, хуулийн этгээдүүдийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдийг эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжих, гадаадад гэрээгээр ажиллагсдын нийгмийн хамгаалалыг сайжруулах, Монгол туургатны харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Эвсэлд үл нэгдэх, төвийг сахих

- Цөмийн эрчим хүчийг ашиглах бэлтгэл ажлыг бүрэн хангах тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх хүрээнд гарах сөрөг үр дагварыг нарийвчлан тооцох, уран болон цацраг идэвхит бусад бодисыг олборлохгүй, цөмийн хаягдлыг газар нутагтаа байршуулахгүй байх бодлогыг хэрэгжүүлснээр цацрагийн хор хөнөөлгүй улс болохоо олон улсад тунхаглаж, үндсэн хууль, бусад холбогдох эрх зүйн баримт бичигт тусгана.
- Хүч үл хэрэглэхийн төлөөх өөрсдийн итгэл үнэмшилд тулгуурлан даян дэлхийн аюулгүй байдлын суурь болох улс хоорондын, нийгэм хувь хүмүүс хоорондын энх тайванч, хамтын ажиллагааны соёлийг төлөвшүүлнэ.
- Улс орныхоо аюулгүй байдлыг зэвсэгт хүчин дээр голлон тулгуурлах бус, улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшил, байгаль орчны аюулгүй байдал, хүний эрхийг хүндлэн дээдлэх, даян дэлхийн улс гүрнүүдтэй энх тайвнаар зэрэгцэн орших зэрэг тулгуур зарчмуудад үндэслэн хамгаална.
- Зэвсэгт хүчний харьцааг тэнцвэржүүлэхийг чухалчилдаг үзэл баримтлалын оронд нийгэм, эдийн засаг, экологи, сэтгэлзүй, соёлын асуудлыг урьтал болгодог даян дэлхийн аюулгүй байдлын цогц үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ.
- Сөргөлдөөнөөс сэргийлэх, түүнийг зохицуулах, шийдвэрлэх чадвартай Монгол Улсын аюулгүй байдлын тогтолцоог бий болгоно.

“Гурван тулгуурт” бодлого

- Монгол улс нь ОХУ, БНХАУ хоёр хөрштэйгөө найрсаг хамтын ажиллагааг өргөжүүлж Монгол улсын “Эвсэлд үл нэгдэн төвийг сахих бодлого”-ыг гадаад харилцааныхаа тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлнэ.
- Хөрш орнуудтайгаа эрх тэгш зарчмыг баримтлан хамтран ажиллаж Монгол улс, ОХУ, БНХАУ хоорондын хил хязгаарын асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч хилийн халдашгүй дархан байдлыг баталгаажуулна.
- Бүс нутгуудын хүрээнд эдийн засгийн жигд хөгжлийн үзэл баримтлалыг бүрдүүлж хөрш орнуудтайгаа хамтран хөгжих бодлогыг хэрэгжүүлнэ.
- Бүс нутгийн эрчим хүчний хангамжид цөмийн цахилгаан станц ашиглах асуудалд шүүмжлэлтэй хандаж боломжит шийдлийг санал болгох, нөхөн сэргээгдэх түүхий эд дээр суурилсан эрчим хүчний эх үүсвэрийг онцгойлон дэмжих орчин үеийн дэвшилтэд техник технологид суурилсан бодлогыг дэвшүүлж хамтын ажиллагааг өрнүүлнэ.
- Хамтын ажиллагааг дэмжих үүднээс гурван улсыг хамарсан дэд бүтцийн цогц сүлжээг бүрдүүлж эдийн засгийн хувьд үр ашигтай байх зарчмыг баримтлана.



- Хөрш орнуудын эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухаан болон нийгмийн халамжийн салбарт өргөн хүрээг хамарсан хамтын ажиллагааг өрнүүлнэ.
- Монгол улс үндэсний эрх ашгаа дээдлэх зарчмыг орхигдуулахгүй байж хөрш орнуудынхаа эрх ашигт харшлах ямар ч үйл ажиллагааг бусад улс орон, олон улсыг хамарсан аливаа эвсэлүүдтэй хамтран явуулахгүй байх төвийг сахих бодлогыг хэрэгжүүлнэ.

“Цэвэр нийгэм”-ийн улсын хил, дотоодын аюулгүй байдлыг хамгаалах цомхон, чадварлаг мэргэжлийн армитай байх, залуу хүн бүр эх орныхоо хил хязгаартай бүрэн танилцах, түүнийг хамгаалах үйл хэрэгт биечлэн оролцож “Ургах нарнаас угтах наран зүг” уриан дор цэргийн алба хаах зэрэг үзэл баримтлалыг “Хилийн цэргийн яам” бодлогоор хангаж амьдралд хэрэгжүүлнэ.

2.2.5. Хилийн цэргийн яам

Мэргэжлийн армитай байх

- Монгол улс түүхт уламжлалдаа үнэнч байж улс эх орноо хамгаалах үзэл баримтлал дээр суурилсан мэргэжлийн армитай байна.
- Монгол улсын арми нь орчин үеийн цэрэг дайны номнол, дэвшилтэт зэвсэг техник, аргачлал дээр тулгуурлан байнгын ажиллагаа байж, үйл ажиллагаагаа цаг үетэйгээ нийцүүлэн тогтмол чадавхижуулна.
- Армийнхаа боловсон хүчний бодлогод онцгой ач холбогдол өгч даян дэлхийн хамтын нийгэмлэгийн хүрээнд үйл ажиллагаа явуулах чадавхитай боловсон хүчнийг бэлтгэнэ.
- Мэргэжлийн арми нь зохион бүтээх, цогцлоон боловсруулах бүтэцтэй байх ба барилга байгууламж, дэд бүтцээ хариуцан ажиллахын зэрэгцээ Монгол улсын бүтээн байгуулалтад онцгой үүрэг хүлээнэ.
- Түүхт уламжлалын үүднээс “Морин цэргийн мянгат” байгуулж армийн сүр жавхаа, “Монгол бахархал”-ын илэрхийлэл болгоно.

Ургах нарнаас угтах нарны зүг

- “Хил, хэл, мал”-аа дээдлэх уламжлалт ухааралдаа тулгуурлан хил хязгаарыг сахин хамгаалах үйл хэрэгт бүх нийтийн оролцоог хангана.
- Хилийн цэргийг “аравт”, “зуут” гэсэн эртний уламжлалт бүтцээр зохион байгуулж зуут зуутаар Монгол улсынхаа хилийг зүүн хязгаараас эхлэн нэг жилийн дотор нар зөв бүтэн тойрох зарчмаар хил хамгаална.
- Эмэгтэйчүүд эрчүүдийн адил цэргийн алба хаах бөгөөд хилийн цэргийн “аравт”, “зуут” нь “өргөө”-чилсэн хөдөлгөөнт байдлаар хилийн цэргийн заставуудаар дамжин хил хамгаалах үйл ажиллагаанд оролцоно.



(Handwritten signatures in blue ink)


- Хил хамгаалах үйл ажиллагааг явган марш, ердийн болон механикжсан төрлөөр зохион байгуулна.
- Хилийн заставууд дээр цэргийн албан хаагчдад зориулсан мэргэжлийн сургалт, урлаг, биеийн тамирын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулна.
- Цэргийн насанд хүрсэн иргэдээр шаардлагатай бол дүйцүүлэх албыг хаалгуулж болно.
- Цэргийн албанд татагдсан иргэд нийслэл хотод цугларч тодорхой хуваарийн дагуу нэг сарын хугацаанд бэлтгэгдэн ургах нарны зүг аравт, зуутын зохион байгуулалтаар очиж, мөн хугацаат цэргийн албаа дуусгаад буцаж нийслэл хотод ирнэ.
- Цэргийн албанд үдэх болон угтах үйл ажиллагааг “Морин цэргийн мянгат”-ыг оролцуулан хүндэтгэл ёслолын хэлбэрээр зохион байгуулж байна.

Аюулаас хамгаалах бодлого

- Монгол улсын нийгмийг аюулаас хамгаалах бодлогыг зангидан хэрэгжилтийг хангах, боловсон хүчнийг бэлтгэх ажлыг зохион байгуулна.
- Цэргийн алба хаасан, мэдлэг боловсролтой, амьдралын туршлагатай, ёс зүйн хэм хэмжээг сахидаг Монгол улсын иргэнийг хүсэлтийнх нь дагуу нийгмийг аюулаас хамгаалах үйл ажиллагаанд дайчлах болно.
- Терроризмтэй тэмцэх, эдийн засгийн болон улс төрийн тагнуул туршуулыг илрүүлэх, сэтгэцийн гажигтай хүмүүсээс, шашны харгис урсгалаас иргэдээ хамгаалах үйл ажиллагааг нийгмийг аюулаас хамгаалах бодлогоор хэрэгжүүлнэ.
- Нийгмийг аюулаас хамгаалах бодлого нь нийгэмд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх зарчимд үндэслэх бөгөөд шаардлагатай үед нийгмийн дэмжлэгт тулгуурлана.

2.3. ЦЭВЭР ЭДИЙН ЗАСАГ

“Цэвэр эдийн засаг” нь байгаль экологи, инновацид суурилсан өндөр бүтээмжтэй аж үйлдвэр, эрчимжсэн технологид тулгуурласан хөдөө аж ахуй, цаг хугацааныг шалгуураар дасан зохицсон уламжлалт мал аж ахуй, нөхөн сэргээгдэх түүхий эдэд шүтсэн эрчим хүч, цогц сүлжээгээр хангагдсан орчин үеийн зам харилцаа, дэд бүтцээс хараат бус барилгажуулалт, төрийн бодит оролцоогоор дэмжигддэг жижиг, дунд үйлдвэр зэрэг олон талт бодлогуудыг жигд хэрэгжүүлэн экологийн баримжаат эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангана.



“Цэвэр эдийн засаг”-ийн байгаль орчинд халгүй экологийн баримжаатай эдийн засгийн тогтвортой хөгжил, баян ядуугийн ялгааг ойртуулах татварын шаталсан тогтолцоо, хөрөнгө оруулалтыг зөв онилсон өрийн дарамтаас ангид байлгах зээл ба өрийн бодит харьцааг хянах зэрэг асуудлыг “Сангийн яам” бодлогоор ханган хариуцаж амьдралд хэрэгжүүлнэ.


2.3.1. Сангийн яам

Экологийн баримжаатай эдийн засгийн тогтвортой хөгжил

- Уламжлалт соёл иргэншлийнхээ байгальд ээлтэй дэвшилтэт шинжийг хадгалсан, хариуцлагатай зах зээлийг бэхжүүлсэн, ногоон эдийн засгийн бодлого барьсан, “Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн орон байна.” гэдэг томъёололыг төрийн бодлого болгоно.
- Монголын ард түмэн гэдэгт өнөө болон хойч үеэ хамруулан ойлгож эх орныхоо нөөц баялгийн эзэн байх аргачлалыг боловсруулна.
- Орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн эрх хэмжээг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог чадавхижуулна.
- Төсвийн хөрөнгө оруулалтыг богино, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд суурилан хэрэгжүүлнэ.
- Төрөөс стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг ашиглахдаа "Ирээдүйн сан"-гийн үзэл санаанд нийцүүлнэ.
- Улсын хөгжил дэвшлийг ДНБ-ий үзүүлэлтээр бус, “аз жаргалын индекс”-ээр хэмжих чиглэл баримтлах болно.
- Эдийн засгийн хүрээнд шударга өрсөлдөөнийг хангах үүднээс гадаад, дотоодын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж, иргэдэд гарааны тэгш нөхцлийг хангах хууль эрх зүйн орчныг хэрэгжүүлнэ.

Татварын шаталсан тогтолцоо, баячуудын татвар

- Экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээ, импортыг орлох үйлдвэрлэлийг онцгой дэмжинэ.
- Татварын нэр төрөл, татвар ногдуулах аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн татварын тогтолцоог боловсронгуй болгоно.
- Онцгой албан татварын нэр төрлийг үндэслэлтэй нэмэгдүүлэх замаар зохисгүй хэрэглээг хязгаарлаж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээнд экологийн татвар ногдуулна.
- Экологийн баримжаатай нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амьдралд хэрэгжүүлэх үүднээс эдийн засгийн тооцоонд экологийн татварыг тусгах хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- Аж ахуйн нэгжийн албан татварыг орлогын хэмжээгээр шатлалтай болгож жилд 200 тэрбум төгрөгнөөс их орологотой аж ахуйн нэгжид 80 хүртэл хувийн ашгийн албан татвар ногдуулах “Баячуудын татварын тухай” хуулийг санаачлан хэрэгжүүлнэ.
- “Баячуудын татварын тухай” хуульд хамрагдсан аж ахуйн нэгжийг татвараас бусад нөхцлөөр дэмжих бодлого боловсруулна.
- Татварын бүсчилсэн тогтолцоог бий болгож Технологийн хөгжилд суурилсан, хувь хөнгөн үйлдвэр, ложистикийн төрөлжсөн бүсүүдтэй болж тус бүсэд үйл ажиллагаа явуулах ААН, ЖДҮ эрхлэгчдэд татварын онцгой хөнгөлөлттэй нөхцөл бий болгоно.



Two handwritten signatures in blue ink are present at the bottom of the page, one on the left and one on the right.

Зээл ба өрийн бодит харьцааг хянах

- Монгол улсын гадаадаас авах зээлийн хэмжээг хязгаарлан хувийн хэвшлийн зээлд төрөөс баталгаа гаргахыг даруй зогсооно.
- Зээлийн төлбөрийг хугацаанд нь барагдуулах бодлогыг хатуу чанд сахина.
- Монгол улсаас хугацаа хэтэрсэн өрийг барагдуулах шат дараалсан арга хэмжээг зээлдүүлэгч талтай харилцан ойлголцлолын үндсэн дээр хэрэгжүүлнэ.
- Зээлийн дээд хязгаарыг бүх ард түмний санал асуулгыг үндэслэн Засгийн газар тогтоож, Улсын Их Хурал баталдаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлнэ.
- Инфляцийг оновчтой удирдан зохицуулж түүнд шууд нөлөөлөх 200 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг улс эх орондоо үйлдвэрлэх бодлогыг дэмжинэ. Экспортын үйлдвэрлэлийг дэмжиж төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг бодитой болгоно.
- Банк, санхүүгийн тогтолцоо, үйлчилгээг хөгжлийн өндөр түвшинд хүрсэн орнуудын нийтлэг жишигт нийцүүлэн боловсронгуй болгож, зээлийн хүүг бууруулан, хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчин бүрдүүлнэ.
- Санхүүгийн зах зээлд шударга өрсөлдөөнийг төлөвшүүлж, банк, барьцаалан зээлдүүлэх болон банк бус санхүүгийн байгууллагаас барьцаа хөрөнгийг хэт бага үнэлэх, зээлийн хүүг хэт өндөр тогтоох шударга бус байдлыг арилгана.
- Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж өрсөлдөх чадвар бүхий үнэт цаасыг гадаадын зах зээлд гаргах нөхцлийг бүрдүүлнэ.
- Улаанбаатар хотыг Зүүн хойт Ази, Төв Азийн бүс нутгийн банк, санхүүгийн томоохон төв болгохыг зорино.
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зориулалт бүхий гадаадын зээлийн дамжуулан зээлдүүлэх хүүг бууруулж, хугацааг нь уртасгана.
- Монгол банкны бодлогын хүүг баялаг бүтээгч нарт нийцсэн хэмжээнд барих арга замыг эрэлхийлнэ.

“Цэвэр эдийн засаг”-ийн экологид ээлтэй, нөхөн сэргээгдэх түүхий эдэд суурилсан эрчим хүчийг улс даяар өргөн ашиглах, хөгжлийн хурдасгуур болох зам харилцааны цогц сүлжээг байгуулах, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийн баталгааг хангах дэд бүтцээс ангид барилгажуулалт зэрэг асуудлыг “Дэд бүтцийн яам” бодлогоор ханган хариуцан хэрэгжүүлнэ.

2.3.2. Дэд бүтцийн яам

Нөхөн сэргээгдэх түүхий эдэд суурилсан эрчим хүч


- Нөхөн сэргээгдэх түүхий эдийг зонхилон ашиглах бодлогыг хэрэгжүүлж нөхөн сэргээгдэхгүй нөөц баялгийг ашиглах бодлогыг хязгаарлан дахин боловсруулан ашиглах эдийн засгийг цогцлоон бүрдүүлнэ.
- Байгалийн баялаг хязгаарлагдмал гэдгийг хүлээн зөвшөөрч нөөц баялгийг ашиглахдаа өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг хангахын тулд хаягдлыг дахин боловсруулж ашиглана.
- Эрчим хүчний зөв зарцуулалттай, байгальд ээлтэй технологийг хөгжүүлж ашиглахыг зорино.



- Монгол Улсын "Эрчим хүчний нэгдсэн систем"-д нөхөн сэргээгдэх түүхий эд дээр суурилсан эрчим хүчний эзлэх хэмжээг 50 хувьд хүргэнэ.
- Баруун, зүүн, Говийн бүсийн эрчим хүчний системийг төвийн эрчим хүчний системтэй холбож хүчин чадлыг нь 2 дахин нэмэгдүүлнэ.
- Эрчим хүчний аюулгүй байдлыг сайжруулж, хоёр хөрш оронтой эрчим хүчний дэд бүтцээр холбогдон, хэрэглээний онцлогтой уялдуулан экспортын асуудлыг оновчтой шийдвэрлэнэ.
- Агаар мандал дахь нүүрс хүчлийн хийн түвшинг аль болох богино хугацаанд 450 ppm болтол хязгаарлах зорилго тавьж Монгол даяар экологийн хувьд цэвэр эдийн засаг руу хурдан шилжих үйл явцыг эхлүүлнэ.
- Нөхөн сэргээгдэхгүй түлшийг шинээр олборлохыг бүрэн зогсоохыг дэмжинэ.
- Унаган ойг огтлох явдлыг 2024 он гэхэд бүрэн зогсооно.
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох газрын гүний, нарны, салхины эрчим хүчийг ашиглах, хадгалах хамгийн үр ашигтай, тогтвортой, шаардлага хангасан технологийг ашиглана.
- Эрчим хүчний тогтвортой эх үүсвэрийг ашиглах, экологид ээлтэй эрчим хүчийг үйлдвэрлэх техник, технологийг хөгжүүлэх судалгааг дэмжинэ.

Зам харилцааны цогц сүлжээ

- Авто зам, нисэх, төмөр зам, усан замын тээврийн тухай хууль, холбогдох стандарт, дүрэм журамд өөрчлөлт оруулж, холбогдох хуулийг шинээр батлан гаргаж зам харилцааны цогц сүлжээг бүрдүүлнэ.
- Олон улсын конвенци, стандартын шаардлага, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тээврийн гэрээ, хэлэлцээрүүдийг шинэчилж, олон улсад нийтээр дагаж мөрдөх гэрээ, хэлэлцээрт нэгдэн орно.
- Авто замын барилга угсралт, засвар, арчлалтын норм дүрэм, стандартыг боловсронгуй болгож Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон авто зам барих технологи нэвтрүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, авто замын туршилт, сорилт судалгааны ажлыг сайжруулна.
- Улаанбаатар хотын авто замыг хот төлөвлөлт, тээврийн бодлоготой уялдуулан сайжруулж дотооддоо устөрөгчийн хураагуурт суурилсан тээврийн хэрэгсэл угсарч үйлдвэрлэх санал санаачлагыг дэмжих бодлого боловсруулна.
- Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн шинэ төрлийг нэвтрүүлж, авто замын хөдөлгөөнд удирдлага, зохицуулалтын ухаалаг тогтолцоог нэвтрүүлнэ.
- Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ байгуулах асуудлыг ашигт малтмалын орд газруудыг ашиглалтад оруулахтай холбон оновчтой төлөвлөн хэрэгжүүлнэ.
- Агаарын тээврийн шинэчлэлийг гүнзгийрүүлэн олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай, хувийн хэвшлийн оролцоо давамгайлсан салбар болгон хөгжүүлнэ.
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх олон улсын нислэгийн аюулгүй байдлыг ханган, олон улсын нислэгийн чиглэл, тоог байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд нийцүүлнэ.




Дэд бүтцээс ангид барилгажуулалт

- Байгаль экологид эвсэг дэвшилтэт техник, технологид суурилсан дэд бүтцээс ангид барилгажуулалтыг дэмжих бодлогыг төрөөс баримтлана.
- Дэд бүтцээс ангид барилгажуулалтын тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх бодлого боловсруулна, технологийн хөгжил дэвшлийг дэмжих үйл ажиллагааг төрөөс анхаарна.
- Зам тээврийн болон барилгын материал, түүхий эдийг орон нутгийн нөөц бололцоог ашиглан үйлдвэрлэнэ.
- Иргэдийг хувийн эзэмшлийн газартаа хамтын нөхөрлөл, хоршоолол байгуулан дэд бүтцээс ангид барилгажуулалт явуулахад бүх талын дэмжлэг үзүүлнэ.
- Барилгын дулаан хадгалалтад стандарт тогтоож хяналт тавьж ажиллана.
- Байгаль экологид сөрөг нөлөөгүй нарны эрчим хүчний халаалтын системийг төвийн дулааны шугамаас алслагдсан барилга, байгууламж, хувийн орон сууц, амралт сувилалын газар, жуулчны баазад нэвтрүүлэх бодлогыг тогтвортой дэмжинэ.
- Нарны эрчим хүчийг ашиглан гудамж талбай, цэцэрлэг, зүлэгний гэрэлтүүлгийн асуудлыг эрчим хүчний хэмнэлттэй нарны коллектороор шийднэ.
- Барилгын халаалт, хэрэгцээний халуун усны системийг цогцоор нь шийдэх нар, салхины эрчим хүчний өндөр хүчин чадалтай хураагуур болон устөрөгчид шингээн шийдвэрлэх бусад тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх бодлого боловсруулна.

“Цэвэр эдийн засаг”-ийн орчин үеийн дэвшилтэт техник, технологид суурилсан эрчимжсэн газар тариалан, олон зуунаар өвлөгдөн ирсэн нүүдлийн орчинд дасан зохицсон уламжлалт мал аж ахуй, төрийн оролцоот жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх асуудлыг “Хөдөө аж ахуй, Аж үйлдвэрийн яам” бодлогоор дэмжин хэрэгжүүлнэ.

2.3.3. Хөдөө аж ахуй, Аж үйлдвэрийн яам

Эрчимжүүлсэн газар тариалан

- Газар ашиглалтыг сайжруулах, ус нөөцлөх усалгаатай тариаланг хөгжүүлэх, биотехнологи нэвтрүүлэх зэрэг бодлогуудыг хэрэгжүүлж эрчимжүүлсэн газар тариаланд шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлнэ.
- Харилцан бие биенээ тэтгэсэн бүтэц бүхий хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах бодлогыг дэмжих болно.
- Дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөдөө аж ахуйн машин, техникийг худалдан авахад аж ахуйн нэгж, фермерүүдэд дэмжлэг үзүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Жимс, жимсний мод үржүүлгийн газруудыг олноор байгуулах бодлого боловсруулна.
- Таримал ургамлын өвчин, хортонтой тэмцэж, сорт, сорилтын чанарыг сайжруулж, хүлэмжийн аж ахуйг улс даяар хөгжүүлнэ.
- Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ.
- Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний болон импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. Орчин үеийн техник, технологитой хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэн хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр



[Handwritten signatures and initials in blue ink]

жигд, хүртээмжтэй хангана.

- Бүс нутагт хүнсний бөөний худалдааны төв, бирж байгуулан борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох бодлого боловсруулна.
- Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний бүх хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн зохистой орчин бүрдүүлж, хүн амыг аюулгүй, хүрэлцээтэй хүнс тэжээлээр хангана.
- Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангана.
- Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, лабораторийн шинжилгээг дэлхийн жишигт хүргэнэ.
- Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулж гадаад зах зээлд онцгой байр суурь эзлэнэ.

Уламжлалт мал аж ахуй

- Олон зууны турш Монгол орны эрс тэс байгаль, цаг уурт дасан зохицож ирсэн бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх бодлогыг үндэсний уламжлалдаа тулгуурлан үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Худаг гаргах, хурын ус хуримтлуулах, булаг шандны усыг нэмэгдүүлэх замаар ашиглагдахгүй байгаа бэлчээрийг усжуулж бэлчээрийн ашиглалтыг сайжруулна.
- Зарим голын усны урсацад тохируулга хийж бороо, цасны усыг хуримтлуулан ган гачигтай үед усжуулах зориулалттай аргачлалыг бий болгоно.
- Бүс нутгийн онцлогийг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлнэ.
- Биотехнологи ашиглан малын эм, тариа, ариутгал, халдваргүйжүүлэгч бэлдмэлийн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Малын тэжээлийн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээг төрийн бодлогоор дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.
- Бэлчээрийн усан хангамжтай хамтатган хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ, шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ.
- Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.
- Биотехнологи, нанотехнологи, ололтыг мал эмнэлгийн оношлогооны техник тоног төхөөрөмж болон эм бэлдмэлийг үйлдвэрлэлд ашиглахыг дэмжинэ.
- Орчин үеийн бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэдэг болон гадаадаас импортолдог аж ахуйн нэгжийг дэмжинэ.

Төрийн дэмжлэгтэй жижиг, дунд үйлдвэр

- Ажлын байр шинээр бий болгох, иргэдийг ядуурлаас гаргах үйлсэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгч хувийн хэвшлийг хөгжүүлэхэд төрөөс онцгойлон анхаарч дэмжлэг үзүүлнэ.
- Жижиг, дунд бизнесийн тодорхойлолтыг тодорхой томъёолж олон улсын жишгийг мөрдлөг болгож хуульчилна. Ингэснээр жинхэнэ жижиг, дунд бизнес эрхлэгч нарт зориулсан төсөл, хөтөлбөрийг эзэнд нь хүргэдэг, ажлын байр нэмэгдүүлэх тугамд татварын хөнгөлөлтийн бодлогоор дэмждэг болгож хуульчилна.



Handwritten signatures in blue ink, likely representing the officials responsible for the document.

- Хувийн хэвшлийн хөгжилд үзүүлэх төрийн оролцоо нь тэдэнд тулгарсан бэрхшээлийг арилгах, тэдний нийгмийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, бараа бүтээгдэхүүнийг нь худалдан авах, гадаад зах зээлд гарах таатай орчин бүрдүүлэх явдлаар хангагдана.
- Нэмүү өртөг бүрдүүлэх, ашигласан нөөц баялгийг дахин боловсруулж эргэлтэд оруулах, эдэлгээ даах бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нөхөн сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, байгаль орчныг хамгаалах, органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх зэрэг эдийн засгийн үйл ажиллагаагаар ажлын байрыг нэмэгдүүлэх зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.
- Бизнесийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд оролцох Засгийн газрын оролцоог зохистой түвшинд хүртэл хязгаарлана.
- Гадаад орны дэвшилтэт сургалтын тогтолцоог нутагшуулах ажлыг хэрэгжүүлэхдээ багшлах боловсон хүчнийг нь урилгаар ажиллуулах бодлого баримтлан нарийн мэргэжлийн хүмүүсийг сурган бэлтгэнэ.
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах эдийн засаг, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн чөлөөт бүс болон эрх зүйн тусгай зохицуулалттай бүсүүдийг байгуулан ажиллуулж өндөр технологи нутагшуулахыг дэмжинэ.
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.
- Экспортын баримжаатай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн татвараар дэмжих бодлогыг баримтлана.
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд төрийн үйлчилгээг, ялангуяа шаардлагатай үед санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай болгоно.
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бизнес инкубаторыг боловсронгуй болгож өргөжүүлнэ.

2.4. ЦЭВЭР БАЙГАЛЬ ОРЧИН

“Цэвэр байгаль орчин” нь эртнээс эдүгээг хүртэл уламжлагдан ирсэн амьд байгалиа хайрлан хамгаалдаг, түүний баялагийг шунаг сувдаг сэтгэлгүйгээр зохистой ашигладаг хүн ардынхаа ариун ёсыг “Даян дэлхийн ногоонтнуудын тунхаг”-ийн үзэл санаагаар баяжуулан эх орныхоо эрдэс баялагийг “Эрдэнэтийн үйлдвэр”-ийг байгуулсан үр дүн, өгөөж хишгийн зарчмаар ашиглаж, ногоон эдийн засгийг улсынхаа хөгжлийн уг үндэс болгож, экологид ээлтэй хөгжлийн бодлогыг хөгжүүлнэ.

“Цэвэр байгаль орчин”-ы Монгол улсын байгаль хамгаалах өв уламжлал, арга ухаанд суурилсан “Дэлхийн экологи Монголоос” гэсэн тулгуур бодлого, эх орны баялагийн ашиглалтын үр өгөөжийг өөрийн улсдаа шингээх “Эрдэс баялгийг Эрдэнэтийн зарчмаар” гэсэн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх, дэлхий дахинаар хүлээн зөвшөөрөгдсөн ногоон эдийн засгийг хөгжүүлэх зэрэг асуудлыг “Байгаль хамгаалал, Ногоон хөгжлийн яам” хариуцан хэрэгжүүлнэ.

2.4.1. Байгаль хамгаалал, Ногоон хөгжлийн яам

Дэлхийн экологи Монголоос



- Монгол орныхоо байгалийг унаган төрхөөр нь хадгалан хамгаалж, түүний баялагийг

хойч үедээ өвлүүлж ирсэн үндэсний уламжлалаа шинэ цагийн “экологид эвсэг” хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан Монгол улсаа хөгжүүлж, энэ үйлсээрээ дэлхий дахиныг манлайлж амьдрал тээсэн цэнхэр гаригийнхаа экологийг аврах эхлэлийг тавина.

- Ургамал, амьтны аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлаж байгалийн жамаар нөхөн үржих орчныг хамгаалж, тэдгээрийг тогтвортой ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.
- Хүний ёсонд үл нийцэх амьтны амь бүрэлгэх “Ан агнуурын аялал жуулчлал”-ыг хуулиар хориглоно.
- Экосистемийн нэгдмэл байдал, биологийн төрөл зүйлийг хадгалан хамгаална.
- Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хэвийн өсөлтийг хангах, зориудын аргаар үржүүлэх, генийн санг хамгаалахад биотехнологийн ололтыг ашиглаж биологийн найдвартай нөөцтэй болно.
- Олон улс, бүс нутгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах бодлого, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын зэрэгцээ Монгол улсын газар нутгийн 30 хүртэлх хувийг Улсын тусгай хамгаалалтад авах төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- Хүрээлэн буй орчинд хор нөлөө өндөртэй үйлдвэрлэл, үйл ажиллагааг хугацаа болон ашиглалт, стандартын шаардлагаар хязгаарлах бодлого баримтлана.
- “Байгаль орчныг бохирдуулагч нь төлөгч”, “ашиглагч нь хамгаалагч” байх үзэл санааг хэрэгжүүлнэ.
- Говь, хээрийн бүсэд мод тариалж ногоон зурвас байгуулах “Ногоон хэрэм” хөтөлбөрийг үргэлжлүүлж, ойн сангийн 20 хүртэлх хувийг нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэн ойн санг бүрдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах хариуцлагын тогтолцоо боловсронгуй болгоно.
- Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцлийг хангах “Ой” үндэсний хөтөлбөрийг дэмжинэ.
- Газар зүйн мэдээллийн тогтолцоонд суурилсан ойн мэдээллийн сан байгуулна.
- Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах “Ус” үндэсний хөтөлбөрийг дэмжинэ.
- Гол мөрий ай савыг ойжуулах ажлыг нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлнэ.
- Туул голын экосистемийг сэргээн хамгаалж, Тэрэлж орчмын хэсэгт цөөрөм байгуулах судалгааг эхлүүлж, судалгаа шинжилгээнд суурилах замаар нийслэлийн ундны усны хангамжид гадаргын усыг ашиглах боломжийг бүрдүүлнэ.
- Байгаль нуурийн экологийн төлөв байдлыг баталгаажуулах үүднээс Улаанбаатар хотын бохир усныг цэвэрлэх аргачлалыг олон улсын жишигт нийцүүлнэ.
- Улаанбаатар хотын экосистемийн хямрал буюу агаар, хөрс, усны бохирдлыг зогсоох цогц бодлого боловсруулна.

Ногоон эдийн засаг

- Төв азийн нүүдлийн соёл иргэншлийн өвийг авч үлдсэн Монгол улсынхаа илт давуу талыг суурь болгон “Ногоон эдийн засаг”-ийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах санал санаачлагыг дэмжиж бодлого баримтлах болно.
- Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлоготой болно.





(Handwritten signatures and marks)

- Бохир усыг цэвэршүүлэн хүнсний хэрэгцээнээс бусад зүйлд дахин ашиглах орчин үеийн техник, технологийг эх орондоо нэвтрүүлнэ.
- Шинэ дэвшилтэт техник, технологид тулгуурлан "Ямааны ноолуур, тэмээний ноос, хонины нарийн ноос боловсруулах", "Арьс ширний үйлдвэрлэлийг хөгжүүлэх" зэрэг бүс нутгийг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.
- Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн арга технологийг олон улсын жишигт нийцүүлэнэ.
- Технологи нутагшуулах бодлого баримталж өөрийн оронд үйлдвэрлэх боломжтой хүнсний болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг импортоос хэт хараат байдлыг багасгана.
- Бүс нутагт үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааг жигдрүүлнэ.
- Улирлаас үл хамаарсан "Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр" боловсруулах санал санаачлагыг дэмжих бодлого баримтлах ба аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгохыг эрмэлзэнэ.

Эрдэс баялгийг Эрдэнэтийн зарчмаар

- Монгол улс ногоон хөгжилд суурилсан "хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн орон болох" үндсэн зорилгоо "Эрдэс баялагийг Эрдэнэтийн зарчмаар" гэсэн бодлогоор хэрэгжүүлнэ.
- Стратегийн ордыг олборлохдоо ажилтан, албан хаагчдын амьдрах таатай орчныг бүрдүүлсний үндсэн дээр ашиглалт, олборлолтыг эхлүүлнэ.
- Эх орныхоо байгалийн баялагийг ашиглах, олборлохдоо гадаадын хөрөнгө оруулалтыг дайчлах тохиолдолд Монгол улсын засгийн газар хамгийн багадаа ашгийн 51 хувийг эзэмших нөхцлийг баталгаажуулна.
- Уул уурхайн лицензийн наймаа арилжааг хуулиар хориглож, худалдагдсан лицензүүдийг хураан авах асуудлыг шийдвэрлэнэ.
- Уул уурхайн нөхөн сэргээлтийн зардлыг олборлолт эхлэхээс нь өмнө төрийн санд төвлөрүүлж, нөхөн сэргээлтэд шаардагдах нэмэгдэл зардлыг тухай бүрд нь гаргуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Эдийн засгийн шударга өрсөлдөөнийг хангах үүднээс гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд гарааны ижил нөхцлийг хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Эрдэсийн болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг үе шаттай бууруулж, оюуны шингэц бүхий бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжинэ.
- Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулна.

Цэвэр төрийг цогцлоон байгуулах тулгуур багана болсон "Цэвэр нийгэм", "Цэвэр эдийн засаг", "Цэвэр байгаль орчин" гэсэн гурван үндсэн хүрээний зорилтуудыг хангах замаар "Гурван цэвэр"-ийн бодлогыг хэрэгжүүлж байгаль орчинд ээлтэй оюун санаа, нийгэм, эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалтыг цогцлоохын хамт өмнөх засгийн газрын үргэлжлүүлэх шаардлагатай үйл ажиллагааг улам төгөлдөржүүлэн заргамжлахыг бий эрмэлзэх болно.

ГУРАВ. ЦЭВЭР ТӨРИЙН ХҮЛЦЭШГҮЙ 13 АЛДАС

Монгол улсын үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулах, гамшиг дагуулах онц ноцтой үр дагавар бүхий дараах алдаа гэмийг “Цэвэр төр”-ийн хүлцэшгүй 13 алдас хэмээн хатуу цээрлэнэ. Үүнд:

1. Төрийн “Хар хайрцагны бодлого”-ын гажуудуулах, умартах;
2. Монгол улсын хууль эрх зүйн орчныг үл тоомсорлох, дагаж мөрдөхгүй байх;
3. Үндэсний өв уламжлалыг үл хүндлэх, гутаан үгүйсгэх, бүрхэгдүүлэх;
4. Монгол улсын эрх ашгаас ухрах, эх орноосоо урвах;
5. Эзэн Чингис хаан болон өвөг дээдсийн нэр хүндэд үл хүндэтгэлтэй хандах;
6. Авлига, хээл хахуульд өртөх;
7. Хүний эрхийг зөрчих, хүүхдийн эрхийг үл ойшоох;
8. Хөрш орнуудын үйл ажиллагаанд хөндлөнгөөс хошуу дүрж, үл хүндэтгэлтэй хандах;
9. Олон улсын хамтын ажиллагааны хэм хэмжээ, эв найрамдлыг эрхэмлэхгүй байх;
10. Цөмийн цахилгаан станц байгуулах, цацраг идэвхит ашигт малтмалыг олборлох, боловсруулах, цөмийн хог хаягдлыг булшлахыг дэмжих;
11. Байгаль дэлхийтэй зүй бус харьцах;
12. Монгол үндэстний өв уламжлалд харшлах шашны урсгал, гаж үзэгдэл, сэтгэлгээг олон түмэнд сурталчлах;
13. Монголчуудын дотоод асуудалд хөндлөнгөөс оролцох зорилготой гадаадаас үүсэл гаралтай аливаа үйл ажиллагаанд оролцох;

ДӨРӨВ. “ЦЭВЭР ТӨР”-ийг сонгох “НОГООН СОНГОЛТ”

Монгол төрийн дээр гарсан намууд, тэдгээрийг дамжсан олигархи бүлэглэлүүд ард түмнийг ядууруулж, нийгмийн баялгийг шударга бус хувиарлан хямралт байдлыг бий болгож байгаа тул Монголчууд бид Үндсэн хуулиар олгогдсон “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна.” гэсэн язгуур эрх мэдлээ эдлэж “Ногоон сонголт”-оор засгийн эрхийг авахыг “Сонгуулийн хувьсгал” гэж МНН ойлгож байна.

Бид сонгогч түмэнтэйгээ хамтран “Гэрийг шинээс нь, гишүүнийг цэврээс нь” уриан дор “Сонгуулийн хувьсгал”-ыг хийх болно.

Монголын улс төр, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

- Хуурамч амлалтаар сонгогдон төрд шургалсан, төрөөс төрсөн төрбумтнууд улс орны эрх ашгаас илт урваж хөрөнгө мөнгө амласан харийнхны сонирхол, бодлогын тоглоом, гар хөл болон хувирсан байна.
- Үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөө, шударга ёс, ардчилал алдагдаж эдийн засаг унаж, иргэд элгээрээ мөлхөж, ажилгүйдэл, ядуурал газар авлаа.
- Нам дамнасан бүлэглэлүүдийн тохиролцоо, тэдний мөнгөний шуналаар төрийн бодлого тодорхойлогдох боллоо.
- Улс эх орны нэрээр гадаадаас их хэмжээний зээл авч хяналтгүй зарцуулан, хуваан завшиж нийгэмд шударга бус байдал тогтоолоо.



(Handwritten signatures in blue ink)

- “МАНАН” гэсэн нэрд нэгдсэн хоёр том улс төрийн бүлэглэл тохиролцож байгаад дуртай үедээ өөрсдийн эрх ашигт нийцүүлэн хууль цаазыг өөрчилж болдог жишиг тогтоолоо.
- Төрийн оронд намууд дангаараа ноёрхож, намуудын хуйвалдаан, талцлын улмаас улс орон туйлдлаа.
- Хөрөнгөтэй мөнгөтэй хүмүүсийг төрд гаргаснаар улс төрийн онол, улс төрийн боловсрол орхигдож, эрх мэдэл дагасан мэдлэг боловсролгүй, ёс суртахуйнгүй, амьдралын зарчимгүй хүмүүс төрд олширч хувийн эрх ашгийг хөөцөлдөж төр түмний эрх ашгаас урваж байна.

Хувьсгалын тохироо

- Монгол улсын төрийн эрх барьж байгаа нам “дотроосоо өтөж” улс төрийн өндөр албан тушаалтнууд, тэдгээрийн бүлэглэлүүд хувийн явцуу эрх ашгийн үүднээс төрийг самууруулж, улмаар үндэсний аюулгүй байдалд хор уршиг тарихуйц улс төрийн нөхцөл байдал үүсээд байна.
- Дээдэх нь захирч чадахаа байж, доодчуул нь тэднээр удирдуулахыг хүсэхээ байсан ийм нөхцөлд хувьсгал хийдэг тул “сонгуулийн хувьсгал” хийх цаг, тохироо бүрдсэн.
- Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон төрийн эрх мэдлийг жинхэнэ утгаар нь ард түмэнд эргүүлэн өгөх хувьсгал хийж чадах үндэсний улс төрийн нам, улс төрчид бэлтгэгдсэн.
- УИХ-ын сонгуульд ард түмэн зөв хүмүүсээ сонгох замаар сонгуулийн хувьсгалыг хийхэд бэлэн болсон.
- Ард түмний орлого хомсдож, өрийн дааж давшгүй дарамтад орж нийтээрээ ядууралд өртөх аюул нөмөрсөн.

Хувьсгалын үр дүн



- Монголын ард түмэн Үндсэн хуулиар олгогдсон эрх мэдлээ жинхэнэ утгаар нь эдлэж “Сонгуулийн хувьсгал”-аар нам дамжсан олигархи бүлэглэлүүдээс төрийнхөө эрх мэдлийг буцаан авна.
- “Сонгуулийн хувьсгал”-аар монголчууд бид улс орныхоо гэрэлт ирээдүй, ард түмнийхээ аз жаргалтай амьдралыг нуруундаа үүрч чадах эрдэм билиг төгөлдөр, эх орон, хүн ардаа гэсэн халуун сэтгэлтэй, ёс зүйтэй, шударга хүмүүсийг төрд гаргана.
- Ард түмний итгэл найдварыг хөсөрдүүлдэг, улс орны хөгжлийг уруудуулдаг “увайгүй түшээд”, “амьгүй албатууд”-ыг “Сонгуулийн хувьсгал”-аар эргүүлэн татах боломжийг олж авна.
- Ард түмний шударга томилолтыг аван гарч ирсэн албатууд төр түмнийхээ сайн сайхан амьдрал, хөгжил дэвшлийн төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр, өөрийн биеийг үл хайрлан үнэнчээр зүтгэж ард түмнийхээ хамтаар “Цэвэр төр”-ийг цогцлооно.



Монгол улс өнө мөнх оршиг!
МОНГОЛЫН НОГООН НАМ

Монгол Улсын Үндэсний Аудитын газрын

2020 оны 04 дүгээр сарын 21 -ны өдрийн 1245 тоот дүгнэлтээр баталгаажуулав.





МОНГОЛЫН НОГООН НАМД

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.21 № 1245
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох “Монголын ногоон нам”-аас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020” Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

“Монголын ногоон нам”-аас Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Монголын ногоон нам”-ын мөрийн хөтөлбөр ¹²⁴⁵ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сонгуулийн Ерөнхий хороонд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0421NAG39.Docx

001052193